

МЭРГЭЖЛИЙН АНХАН ШАТНЫ СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН БАГШ БЭЛТГЭХ ЗОРИЛТ

Д. Батчимэг

Abstract This referat is written in order to prepare master and engineer teachers of professional school in our country and also research the ways how to develop and implement.

Түлхүүр үг: Инженер багш, мастер багш. Мэргэжлийн сургууль

Удиртгал. Мэргэжлийн сургуулиудын өнөөгийн байдал

Манай улсын боловсролын тогтолцоонд Мэргэжлийн анхан ба дунд шатны сургуулиуд Онцгой байр суурийг эзэлнэ. Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа нь олон салбар яамдын оролцоотойгоор зохицуулагддаг, хөдөлмөрийн зах зээл, улс орны эдийн засгийн хөгжилтэй шууд хамааралтай, Нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулдаг хөдөлмөрийн зах зээлээс хамааран байнга хувьсан өөрчлөгдөж байдаг боловсролын тогтолцооны өвөрмөц нэг хэсэг юм. Маш их эрчтэй хурдтай явагдаж буй Шилжилтийн жилүүдэд мэргэжлийн боловсролын салбарт гарсан гол өөрчлөлтүүдээс товчхон дурдъя.

Төр засгаас ихээхэн анхаарч, эрхзүйн хүрээнд анх удаа мэргэжлийн боловсролын хуультай болж, сурагчдад тэтгэлэг олгож эхлэв. Нийгмийн хандлага сургалтын төв рүү чиглэж, нэр хүнд нь дээшилж, өндөр ур чадвартай ажилтны эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж, тухайн бүс орон нутгийн ажиллах хүчний хэрэгцээг хангах чиглэлээр төрөл бүрийн МСҮТ-д бий болж, Улаанбаатар, Дархан, Дорнод зэрэг хотуудад шаталсан бүтэцтэй МСҮТ-ов, Коллежууд байгуулагдаж мэргэжил эзэмшүүлэхийн зэрэгцээ боловсролоор шат ахиулах, мэргэжлийн анхан, дунд улмаар Дээд шатны боловсролыг шатлан эзэмшүүлэх шинэ хэлбэрийн сургуулиудыг бий болгосон. Мэргэжлийн анхан шатны сургууль амжилттай Төгсөгчдөд мэргэжлийн дагуу дэвшин суралцаж, боловсрол, мэргэжлийн түвшингээ ахиулах боломж бүрдсэн, төгсөгчид шууд ажлын байраар хангагддаг, сургууль, суралцагчид,

сургах мэргэжил, багшлах бүрэлдэхүүнд тоон болон чанарын олон эерэг өөрчлөлтүүд гарсан зэрэг өөрчлөлтүүдийг дурдаж болно. Гэвч эрэлтээ тодорхой судалдаггүй, нийгмийн түншлэлийн механизм сул, сургалтын орчин багшийн ур чадвар, мэргэшил, сургалтын технологи арга зүй шинэчлэгдээгүй, санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээ муутай зэрэг сөрөг талуудыг нэрлэж болно. Эдгээрийн дотроос манай салбарын өмнө тулгамдаж буй нэг гол асуудал нь эрчтэй өөрчлөлтөд зохицон ажиллах, мэргэжлийн анхан болон дунд шатны сургуулийн багшийг бэлтгэх, шинэчлэх асуудал юм.

Үндэслэл:

Мэдээлэл технологийн шинэ зуунд мэргэжлийн багш бэлтгэх тогтолцоо бүрдээгүй, залуу багш нарыг дадлагажуулан бэлтгэх залгамж холбоо тасарсан, мэргэжлийн багш нарын сурган заах аргазүй, сургалтын технологийн тухай мэдлэг, чадвар дутмаг, мэргэшсэн инженер, мастер багшийн тоо цөөрсөн, мэргэжлийн хичээлийн тоо, заах цагийн норм нэмэгдсэнээр багшийн хэрэгцээ өсөж, шаардлага хангах багш дутагдах, ирээдүйд МСҮТ-н тоо нэмэгдэх хандлагатай байгаа зэрэг нь ирээдүйн зууны өндөр ур чадвартай мэргэшсэн багш бэлтгэх тогтолцоог бий болгох, мэргэжлийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах бүсийн Төвийг байгуулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ асуудлыг улсын хэмжээнд зохион байгуулдаг ч, орон нутагт тухайлбал, Дархан уул аймагт өөрийн болон төвийн бүсийн аймгуудын /барилга, техник технологи, хаа-н/ мэргэжлийн сургуулиудын хэрэгцээт багшийг хангах материаллаг баз, боломж байна гэж үзэж байна. Иймд дараах зорилгыг дэвшүүлж байна.

Зорилго

- Улс орны нийгэм эдийн засаг, үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлэгч, мэдлэгт суурилсан өндөр ур чадвар эзэмшсэн, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж чадахуйц, олон талт чадварлаг, мэргэжлийн багш бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх, Мэргэжлийн багш нарын мэргэжил Дээшлүүлэх,

мэргэшүүлэх, давтан сургах сургалтын төв байгуулах

Зорилт

- Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, дидактикийн дээд боловсрол олгох төвлөрсөн тэнхим байгуулах:
- Шинэ зууны олон талт мэргэжлийн чадварлаг багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, төслийг шинээр боловсруулах:
- Их, дээд сургуулиудад тодорхой мэргэжлийн барилга, хөнгөн хүнс, техник технологи, Х.А.А, анагаах-н чиглэлээр бакалавраас дээш боловсролтой багш инженер, дипломын дээд боловсролтой багш мастер бэлтгэх анги салбар нээх:
- Үйлдвэрлэлд ажиллаж байгаа инженер, техникчид, шаталсан сургалттай сургууль болон МСҮТ-д амжилттай суралцаж буй шилдэг сурагчдыг багш болох сонирхлыг нь харгалзан элсэлтийн судалгаа хийх:
- Барилгын үйлдвэрлэл, пүүс, компани, үйлдвэр үйлчилгээний газар зэрэг ажил олгогчийн оролцоог бататгаж, холбоо тогтоон түншлэл байгуулах,
- Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах зардлыг төсөвт тусгайлан тусгах, гаднын зээл тусламж төслийн дийлэнх хэсгийг энэ чиглэлд хандуулах, мэргэжлийн багшийн цалинг үйлдвэрлэлийн инженер техникийн ажилтны цалинд ойртуулах, багш бэлтгэх сургуулийн оюутанд тэтгэлэг олгох гэх мэт.

Хэрэгжүүлэх арга зам /дэвшүүлж буй санаа/

- Дархан уул аймагт ТИС-г түшиглэн цомхон бүтэцтэй сурганы төв тэнхим байгуулан, МУИС, БИС, ШУТИС, ХААИС, ТДС, ДадС-н эрдэмтэн багш нартай хамтран нийгмийн түншүүдийн оролцоотойгоор багшийн мэргэжлийн боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сурган сэтгэл судлал дидактикийн асуудлууд, үйлдвэрлэлийн ба багшлах дадлагыг оролцуулсан иж бүрэн сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх: • Төрөл бүрийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд болон шинээр элсэн орсон оюутнуудыг 2, 3-р курсээс нь багшлах сонирхлоор нь нэгтгэн нэг анги курс болгон мэргэжлийн сурган сэтгэл судлал, заах аргазүйн нэмэлт кредит судлуулан багш-инженерийн хос мэргэжлээр төгсгөх боломжтой юм.

• Гадаадад Орос, Герман, Солонгос, Япон зэрэг орнуудад багш бэлтгэх боломжийг судлан, шинэ техник технологи нэвтрүүлэх шаардлагатай мэргэжлүүдээр цөөн тооны багш бэлтгэх, гадаадын мэргэжилтэн багшийг урьж ирүүлэх нь олон багшийг сургах, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, мэргэжилтнийг дагаж оюуны хөрөнгө оруулалт орж ирэх зэрэг олон сайн талуудтай юм.

• Шинэ төгссөн инженер нь мэргэжлийн практик чадвар сул, багшлах ажлын шаардлага хангадаггүй. Өндөр боловсролтой, ур чадвар сайтай инженер, мастерууд цалин болон ажлын нөхцөлөөс шалтгаалан тогтвортой ажилладаггүй зэргээс шалтгаалан коллеж, МСҮТ-н төгсөгчдөөс багшлах сонирхолтой, мэдлэг ур чадвар сайтай, мэргэжлийн зэрэгтэй сурагчдыг сонгон шалгаруулж, мэргэжлийн дагуу элсүүлэн сургах нь илүү үр дүнтэй гэдгийг амьдралын туршлага харуулж байна.

• Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн багш бэлтгэхийн тулд нийгмийн түншүүдтэйгээ хамтран хэлэлцэж, үйлдвэрлэлд нэвтэрч буй шинэ техник, дэвшилтэт технологи арга ажиллагааны талаарх мэдээллийг сургалттайгаа нягт уялдуулан, мэргэших, дадлагажих сургалтыг үйлдвэрлэлийн хүрээнд хамтран зохион байгуулж харилцан уялдаатай ажиллах нь чухал юм.


• Коллеж болон МСҮТ-н сургалтын алба, багшлах сонирхолтой сурагчдын судалгаа гаргаж зардлыг тооцон сургуулийн төсөвт суулгах, Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд /2006-2010/ тусгагдсан сургалтын материаллаг баазыг сайжруулах зардлыг жил бүр 10.0%-р өсгөнө гэсэн мастер төлөвлөгөөний дагуу зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Үр дүн: Дээрх ажлыг орон нутагтаа шийдсэнээр эдийн засгийн хувьд хэмнэлттэй, богино хугацаанд мэргэших, мэргэжлээ дээшлүүлэх, онол дадлагын хичээлийг зэрэг заах чадвартай мэргэжлийн багшийн тоо нэмэгдэнэ. Үүний үрээр үндэсний мэргэжилтэн ажилчдын чадавх сайжирч, улмаар үйлдвэрлэг үйлчилгээ хөгжих, эдийн засгийн өсөлт би болоход дэмжлэг үзүүлнэ. Мөн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад нөлөөлнө. Ирээдүйд МСҮТ-н шинэчлэлд, бэлтгэгдсэн мэргэжлийн багш нөлөөлж, өөрчилж, шинэчилж, хөгжүүлж чадна.

Дүгнэлт: Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”-ны бодлого, стратегид нийцүүлэн товлосон зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлснээр, ямар ч насны, ямар ч боловсролтой хүмүүст богино хугацаанд насан туршдаа ажиллаж амьдрах, боловсроход шаардагдах мэдлэг, ур чадварыг олгоход чиглэсэн хувь хүний эрэлтийг хангах, өдөр дутам хувьсан өөрчлөгдөж байгаа ажлын байранд зохицон ажиллах чадвар бүхий ажилтантай болохыг хүсэж байгаа ажил олгогчдын эрэлт, эзэмшсэн мэргэжил боловсролдоо тулгуурлан бие дааж ажил, амьдралаа зохицуулах чадвартай бие хүнийг бэлтгэх нийгмийн захиалгыг биелүүлэх үүргүүдийг шийдвэрлэх ач холбогдолтой юм. Цаашид өөрийн орны мэргэжлийн сургуулиудын ирээдүйн чиг хандлагыг олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан харьцуулж, гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна. Монгол улсаа хөгжүүлэх, дэлхийн төвшинд өрсөлдөх чадвартай иргэн төлөвшүүлэх их үйлстээ хамтдаа зүтгэцгээе!


График 1

1980-1993 оны хооронд политехникийн дээд сургуулиар барилгын инженер багш бэлтгэсэн тоон үзүүлэлтийн график



Нийт 180 гаруй инженер багш бэлтгэгдсэний 10% орчим нь багшилж байна. Насны хувьд хамгийн залуу нь 45 настай байна.

1968-1990 оны хооронд Барилгын техникумаар багш бэлтгэсэн тоон үзүүлэлт



400-аад багш бэлтгэсэний 30% нь багшилж байна. Насны хувьд хамгийн залуу нь 35 настай байна.

Дээрхи үзүүлэлтээс үзэхэд мэргэжлийн багшийн залгамж холбоо тасарсан

(Зөвхөн барилгын мэргэжлийн багшийн үзүүлэлтээр Жишээ авав.

МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Өмнөх үе	Одоо үе	Ирээдүй
Төрөлжсөн хэлбэртэй	Төрөл бүрийн мэргэжлийн чиглэлээр, МСҮТөв	Техник технологийн Чиглэлээр 8 МСҮТөв байгуулна.
Барилгын ТМС	133 мэргэжлээр сургадаг	
ХАА ТМС Хүнсний ТМС		

БАГШ БЭЛТГЭХ БАЙДАЛ

Өмнөх үе	Одоо үе	Ирээдүй
Политехникийн дээд сургуульд барилгын инженер багш 190-1993 оны хооронд 9 удаагийн төгсөлтөөр 250-аад багш бэлтгэсэн.	БШУЯ, Мэргэжлийн боловсролын МАЗТөвөөс төрөл бүрийн мэргэжлийн багшийг мэргэжлийн болон багшлах эрхийн сургалтад суралцуулан багшлах эрх олгож мэргэжлийг дээшлүүлэх давтан сургалтад хамруулж байна.	Шинэ зууны мэргэшсэн боловсролтой мэргэжлийн өндөр ур чадвартай зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн багш, сургагч багш бэлтгэх
Барилгын техникумд 1968-1990 оны хооронд 20 удаагийн төгсөлтөөр барилгын мастер багш 530 бэлтгэсэн.		

Ашигласан номзүй

1. Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө 2006 он.
2. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын дунд хугацааны үйл ажиллагаа төлөвлөгөө /2006-2010/.
3. Хөгжих цагийн боловсрол-Багш нарын улсын анхдугаар зөвлөгөөний эмхэтгэл 2007 он.
4. С.Цээпил (Ph.D), “Мэргэжлийн боловсрол сургалтын сургах зүй” 2006 он.
5. С.Цээпил (Ph.D), “Монгол улсын техник мэргэжлийн боловсрол үүсэл, хөгжил шинэчлэл” 2002 он.
6. С.Цээпил (Ph.D), “Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэчлэл, Хөгжлийн хандлага” илтгэл 2007 он.
7. Б.Жадамбаа “Багш боловсролын ирээдүй” 2006 он.
8. УБ хотын Барилгын техникумын архивын материал.
9. ШУТИС-н БИ Сургуулийн архивын материал.
10. “Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил аргазүйн төв” <http://www.mazt.az.mn> <http://nmc.mn>.
11. Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөгөөн- материалаас, 2007 он.
12. Интернэт мэдээ.

